



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/470

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн БХБЯ/202212088 дугаар гэрээтэй Цээл сумд шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух барих ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандахүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын төсгийн дарга)
	П.Аззаяа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Лхагва-Очир	(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
	О.Мөнхбаатар	(Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
	Ч.Лхагвадулам	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)
	Х.Уранбилэг	(Цээл сумын цэцэрлэгийн эрхлэгч) (ашиглагч)

2.

- Б.Бээжин ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн уйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)  
Н.Бурмаа ("Орон зай консалтинг" ХХК-ийн инженер) (зохиогч)  
Т.Баттөмөр ("Их морьт эрдэнэ" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.Шугам сүлжээний угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Цээл сумын цэцэрлэгийн эрхлэгч (Х.Уранбилэг)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ



